ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS RESEARCH CENTER

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлогын үнэлгээ – сүүлийн үеийн судалгааны үр дүнгээс

2022 оны 5-р сар

И.Одончимэг, Дэд захирал

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Монгол Улсын өрсөлдөх чадварын цогц судалгааг хийн, дэлхийн бусад оронтой харьцуулсан үзүүлэлтүүдийг тодорхойлон гаргаж, танилцуулах замаар улсынхаа бизнес, эдийн засгийн орчныг таатай болгох, улмаар дэлхийд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилготойгоор 2010 онд байгуулагдсан, улс төрөөс хараат бус, ашгийн бус байгууллага юм.

ЭЗБӨЧСТ нь Ногоон эдийн засгийн холбооны (GEC) гишүүн бөгөөд Монгол дахь түнш байгууллагаар ажилладаг бөгөөд ногоон эдийн засгийн талаарх мэдээ, мэдээллийг түгээх зорилготой nogoonhutuch.mn вебсайтыг хөтөлдөг.

Ногоон эдийн засгийн зорилго юу вэ?



www.nogoonhutuch.mn



Ногоон эдийн засгийн холбоо



Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан 2020



Монгол Улсын өрсөлдөх чадвар

Монгол Улс өрсөлдөх чадвараар 64 улсаас 60-д эрэмбэлэгдэж байна.

Эдийн засгийн тамир тэнхээ
58 / 64

Засаглалын үр ашиг
54 / 64

Бизнесийн ашигт ажиллагаа
60 / 64

Дэд бүтэц
62 / 64

ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS RESEARCH CENTER
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан: Факторууд

Эдийн засгийн тамир тэнхээ	Засаглалын үр ашиг	Бизнесийн байгууллагын ашигт ажиллагаа	Дэд бүтэц
Дотоодын эдийн засаг	Төрийн санхүү	Бүтээмж ба үр ашиг	Үндсэн дэд бүтэц
Олон улсын худалдаа	Татварын бодлого	Хөдөлмөрийн зах зээл	Шинжлэх ухааны дэд бүтэц
Олон улсын хөрөнгө оруулалт	Институцын тогтолцоо	Санхүү	Технологийн дэд бүтэц
Хөдөлмөр эрхлэлт	Бизнесийн эрхзүй	Менежментийн хэвшил	Эрүүл мэнд ба хүрээлэн буй орчин
Үнэ	Нийгмийн тогтолцоо	Хандлага ба үнэлэмж	Боловсрол

Хүрээлэн буй орчны дэд бүтэц



Хүрээлэн буй орчны дэд бүтэц



Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Аймгуудын өрсөлдөх чадварын судалгаа

Монгол Улсын 21 аймгийн өрсөлдөх чадварыг харьцуулан судалсан тайланг 2012 оноос тасралтгүй гаргаж байна. ЭЗБӨЧСТ-өөс уг судалгааг хэвлэмэл хэлбэрээр болон aimagindex.mn вебсайтаар хүргэдэг.



Улаанбаатар хотын дүүргүүдийн өрсөлдөх чадварын судалгаа

Улаанбаатар хотын дүүргүүдийн өрсөлдөх чадварыг харьцуулан судалсан тайланг 2017 оноос 2 жил тутамд тасралтгүй гаргаж байна.

НОГООН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ҮНЭЛГЭЭ

МОНГОЛ УЛСЫН НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

ДУНД ХУГАЦААНЫ ТОЙМ

UN environment programme 50 1972-2022

ТАЛАРХАЛ

Энэхүү тайланг НҮБ-ийн Байгаль орчны хөтөлбөр болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хүсэлтийн дагуу Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (Ихбаярын Одончимэг, Гончигсумлаагын Ганзориг, Батцолмонгын Мөнгөнжигүүр)-ийн зүгээс бэлтгэсэн болно. Энэхүү тайланг "Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд хүртээмжтэй ногоон эдийн засгийн бодлого боловсруулах" теслийн хүрээнд Европын холбоо санхүүжүүлж НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс боловсруулсан ногоон эдийн засгийн бодлогыг хянах арга зүйд үндэслэсэн болно. Тус тайлангийн зохицуулагчаар НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Нөөц ба зах зээлийн газрын Клаудиа Ассманн ажиллаж,Фулай Шенг, Стивен Стоун нар чиглэл өгсөн. Түүнчлэн НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс Жозеф Прайс, Анна-София Элм нар тайлантай танилцаж, эцэслэхэд туслав.

Европын холбоо санхүүжүүлэв.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS RESEARCH CENTER
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

ГАРЧИГ

Хураангуй
1 Удиртгал
2 Бодлогын хэрэгжилтийн үнэлгээ
3 Дүгнэлт, зөвлөмж
4 Ашигласан материал
5 Хавсралт

АГУУЛГА руу БУЦАХ

ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS RESEARCH CENTER
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

Ногоон эдийн засгийн бодлогын үнэлгээ: Дунд хугацааны тойм

1. **Удиртгал** 1
   - 1.1. Ногоон хөгжлийн бодлого 2
     - *НХБ-ын шалгуур үзүүлэлт* 3
     - *Ногоон хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтийг бусад бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулсан нь* 4
   - 1.2. Үнэлгээний арга зүй, хамрах хүрээ 4
2. **Бодлогын хэрэгжилтийн үнэлгээ** 7
   - 2.1. Бодлого боловсруулах үйл явц 7
   - 2.2. Бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа 9
   - 2.3. НҮБ -ын тогтвортой хөгжлийн зорилтууд болон үндэсний бодлогын баримт бичгийн уялдаа 10
     - 2.3.1. Алсын хараа - 2050 10
     - 2.3.2. Тогтвортой хөгжлийн зорилтууд 13
   - 2.4. Шалгуур үзүүлэлтийн биелэлт 14
3. **Дүгнэлт, зөвлөмж** 21
4. **Ашигласан материалын жагсаалт** 23
5. **Хавсралт** 26
   - 5.1. Ярилцсан хүмүүсийн жагсаалт 26
   - 5.2. Уншиж танилцсан баримт бичгийн жагсаалт 27
   - 5.3. Тогтвортой хөгжлийн зорилгын биелэлт 27
   - 5.4. “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030” бодлогын биелэлт 29
   - 5.5. “Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилт” хэлэлцүүлгийн үеэр гарсан санал 31

1.Ногоон хөгжлийн бодлого



- Монгол Улс Ногоон хөгжлийн бодлогыг (НХБ) 2014 онд соёрхон баталснаар ногоон хөгжлийн үндэсний бодлоготой болсон анхдагч улсуудын нэг болов.

- 2020 оны их хурлын сонгуулийн өмнө Монгол Улсын их хурал (УИХ) “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан. Ингэснээр 2016 онд баталсан өмнө нь хэрэгжиж байсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хүчингүй болсон.

- “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын давхардлыг харгалзан үзэж, НХБ-ыг 2021 оны 11-р сард хүчингүй болсон

2. Судалгааны аргачлал, ач холбогдол

- Тус судалгааг НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс 2020 онд боловсруулсан бодлогын үнэлгээний аргачлалын дагуу хийж гүйцэтгэв.

- Судалгааны аргачлалын хувьд:
  - Бодлогын баримт бичгүүд, түүний биелэлтийн тайлан болон бусад тоон мэдээллийг үнэлэв
  - Бэлдсэн асуултуудын дагуу уулзалт, ярилцлагууд зохион байгуулсан,
  - Тусгайлсан хэлэлцүүлэг хийсэн

Энэхүү судалгааны зорилго нь Ногоон хөгжлийн бодлогын дунд хугацааны хэрэгжилтийг үнэлэхийн зэрэгцээ тус бодлого нь үндэсний болон олон улсын хэмжээний бодлого хөтөлбөрүүдтэй хэрхэн нийцтэй байгааг судлах явдал юм.

UN environment
United Nations Environment Programme

ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS RESEARCH CENTER
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

2. Бодлогын хэрэгжилтийн үнэлгээ

- Ногоон хөгжлийн бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтүүд нь ”Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого болон ТХЗ-д хэрхэн тусгагдсаныг бид нийцлийн хувь хэмээх үзүүлэлтээр илэрхийлсэн.

- Нийцлийн хувийг “хангалттай сайн”, “хангалттай”, “хангалттай бус”, “хангалтгүй” гэж үнэлсэн.

2. Бодлогын хэрэгжилтийн үнэлгээ: Алсын хараа 2050

Стратегийн зорилтуудын харьцуулалт:

- Холбогдох дүн шинжилгээнд дурдсанчлан эдгээр бодлогын баримт бичгийн зорилтуудын ерөнхий нийцэл нь “хангалттай” байна. Өөрөөр хэлбэл ногоон хөгжлийн бодлогын 6 зорилтын дийлэнх нь “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан байна.

Зорилт 1: Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлнэ	хангалттай
Зорилт 2:Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.	хангалттай сайн
Зорилт 3: Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, байгаль хамгаалал, хүний хөгжил, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	хангалттай бус
Зорилт 4:Ногоон ажил эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.	хангалттай
Зорилт 5: Байгальд зохицсон ахуй, соёлын үнэт зүйлсийг хөгжүүлж, боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацыг ногоон хөгжлийн хурдасгуур болгоно.	хангалттай сайн
Зорилт 6: Уур амьсгалын өөрчлөлт, бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхад нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ.	хангалттай сайн

2. Бодлогын хэрэгжилтийн үнэлгээ: Алсын хараа 2050

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны харьцуулалт:

“Ногоон хөгжлийн бодлого”:
Стратегийн **6** зорилт,
52 үйл ажиллагаа

“Алсын хараа 2050”:
9 зорилго,
958 үйл ажиллагаа

Үүнээс

“Алсын хараа 2050”-ын 6-р бүлэг “Ногоон хөгжил”:
64 үйл ажиллагаа (7%)

НХБ-ын хэрэгжүүлэх нийт 52 үйл ажиллагааны 35 нь “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод хангалттай сайн, 8 нь хангалттай, 5 нь хангалттай бус, 3 нь хангалтгүй, 1 нь огт тусгагдаагүй байна

2. Бодлогын хэрэгжилтийн үнэлгээ: Алсын хараа 2050

Шалгуур үзүүлэлт

НХБ-ын 2020, 2030 хүртэлх 52 үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх 14 шалгуур үзүүлэлтүүдийг "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогын 958 үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулав. Үр дүнд НХБ-ын 14 шалгуур үзүүлэлтийн 8 нь хангалттай сайн, 1 нь хангалттай бус, 3 нь хангалтгүй, 2 нь "Алсын хараа-2050" огт тусгагдаагүй байна

2 бодлогын шалгуур үзүүлэлтүүдийг агуулгаар нь авч үзэхэд нийт 4 үзүүлэлт зөрүүтэй байдлаар тодорхойлогдсон байна.

Хүснэгт 3. Зөрүүтэй байдлаар тодорхойлогдсон шалгуур үзүүлэлтүүд

№	Ногоон хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлт	"Алсын хараа-2050"-ын шалгуур үзүүлэлт	Нийцлийн хувь
1	Эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	Хангалтгүй
2	Ногоон хөгжилд зарцуулах зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь 10%	Хангалтгүй
3	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хувь		Хангалтгүй
4	Дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн шинээр байгуулагдах паркийн тоо	Хангалтгүй

2. Бодлогын хэрэгжилтийн үнэлгээ: Тогтвортой хөгжлийн зорилтууд

- Тогтвортой хөгжлийн 16 зорилгыг НХБ-ын стратегийн 6 зорилттой харьцуулахад нийцлийн хувь хангалттай сайн байв.

- ТХЗ-ын далай тэнгисийн нөөцийг хамгаалах тухай 14 дүгээр зорилго нь манай улсад төдийлөн хамаарахгүй тул харьцуулалтад оруулаагүй болно.

- Нийцлийн хувь хангалттай сайн байгаа нь манай улс НХБ-ыг дэлхийн нийтээр даган мөрдөж байгаа тогтвортой хөгжлийн зорилгуудтай маш сайн уялдуулж, үндэсний онцлогт тохируулан нарийвчлан задалж баталсныг илэрхийлж байна.

3. Дүгнэлт, зөвлөмж

- ТНХБ-ыг УИХ-аар 2014 онд баталсан нь олон улсын өмнө хүлээсэн үүрэг, зорилгын дагуу ногоон хөгжлийн суурийг тавьж, ногоон эдийн засагт шилжих хүсэл эрмэлзэлтэй байгаагаа нотлон харуулсан үйл явдал болсон.

- Тодорхой зорилго, зорилтууд болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг дэвшүүлснээр НХБ нь Монгол Улсын хувьд ногоон хөгжлийн түүхэн үйл явдал болсон.

- НХБ нь судалгаанд харьцуулсан урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаатай байхын зэрэгцээ дараа, дараагийн бодлогын баримт бичгүүдийн үндэс болсон нь харагдаж байна.

- НХБ болон “Алсын хараа 2050” бодлогын байримт бичгийн хоорондын нийцлийг хангалттай гэж дүгнэж байна. Өөрөөр хэлбэл “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг 2030 он дуустал амжилттай хэрэгжүүлэхэд ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийн дийлэнх хувь хангагдах боломжтой юм.

3. Дүгнэлт, зөвлөмж

- Дунд хугацааны гүйцэтгэлийг зорилтот түвшинтэй харьцуулахад тооцоололд ашиглаж болох 10 шалгуур үзүүлэлтийн 7 нь 2020 оны зорилтод түвшний 70-с илүү хувийг хангасан бол 4 шалгуур үзүүлэлт 90-с илүү хувийг биелүүлсэн байна. НХБ нь ТХЗ болон “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичигтэй нягт уялдаатай байна.

- Дунд хугацааны зарим зорилтууд биелэгдээгүй байгаа нь НХБ-ын зорилго, зорилтод хүрэхэд тодорхой хэмжээний хүндрэл бэрхшээл тулгарсныг харуулж байна.

Тухайлбал, **үйл ажиллагааны санхүүжилт хангалтгүй**, **оролцогч талуудын бодлогын зорилгын талаар ерөнхий ойлголт сул**, **хяналт үнэлгээний систем дутмаг** болон **зарим шалгуур үзүүлэлтүүдийг хэрхэн үнэлэх нь тодорхойгүй** байна. Бодлогын хэрэгжилтийг хангах хэрэгслүүд хангалттай байгаа ч **4 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тооцох боломжгүй, хэрэгжилтийг хэмжих, тайлагнах нэгж тодорхойгүй** хэвээр байна.

3. Дүгнэлт, зөвлөмж

бичиг боловсруулахад тавигдах стандарт, шалгуур үзүүлэлтүүдэд суурь судалгаа, нөлөөллийн дүн шинжилгээ, мэдээллийн бэлэн байдлыг шаарддаг.

Судалгааны үр дүн, зөвлөмжийг нэгтгэн дүгнэвэл:

- НХБ-ыг Монгол Улсын Хөгжлийн бодлогын тухай хууль болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан шинэчлэхдээ анхааралтай хандах хэрэгтэй. Учир нь бодлогын шинэчлэлтэй холбоотой батлагдах журам, тушаалууд нь үйл ажиллагаа, санаачилга, болон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд нөлөөлж болзошгүй юм;
- НХБ, зорилтот түвшинд хүрэхийн тулд ногоон хөгжил, судалгаа шинжилгээ, технологийн салбарт хөрөнгө оруулах Дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд ингэснээр урт хугацаанд нийгэм, эдийн засагт эерэг үр өгөөж авчрах болно;
- Оролцогч талуудын дунд нийтлэг ойлголтыг бий болгож тогтвортой дүрэм, журам тогтоох нь чухал билээ. Тодруулбал, МУЗГ-ын оновчтой зохион байгуулалт, байнгын үйл ажиллагаатай мэдээлэх платформ болон хамтарсан ажлын алба байгуулснаар төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо сайжрах юм;
- Барилга, аялал жуулчлал, хүнсний үйлдвэрлэл, хөдөө аж ахуй зэрэг салбаруудтай хамтран ажиллах замаар банкны салбарын сайн туршлагыг дэлгэрүүлж ТХХТ-ийг бэхжүүлэх шаардлагатай;
- Уул уурхай, үйлдвэрлэл, барилга, худалдаа зэрэг салбарт ногоон стандартыг хэрэгжүүлснээр НХБ, зорилтот түвшинд хүрэхэд эерэг нөлөө үзүүлэх боломжтой;
- Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийг урамшуулах нь НХБ-ыг хэрэгжүүлэх ашигтай хэрэгсэл болно. Ингэхдээ урамшууллын шалгуурыг ил тод, тодорхой байлгах ёстой;
- Төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод ногоон үүргийг тусгаж, албан тушаал дэвших, шагнал олгох асуудлыг авч үзэхдээ нэг шалгуур болгон оруулах нь зүйтэй;
- Иргэд болон аж ахуйн нэгжид ногоон боловсрол олгох замаар ногоон эдийн засагт хандах олон нийтийн хандлага, мэдлэгийг дээшлүүлэх;
- Бодлого төлөвлөлт, хэрэгжүүлэх үйл явцад олон улсын болон дотоодын ТББ, судалгааны төвүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь үр ашигтай байж болно;

Анхаарал хандуулсанд баярлалаа

11-321927

www.ecrc.mn
www.aimagindex.mn
nogoonhutuch.mn

info@ecrc.mn

Twitter / ursulduhchadvar

YouTube / ecrcmn

Facebook / ecrcmn

Instagram / ecrc.mn

ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS RESEARCH CENTER
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ